

БАТЛАВ
АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДЭД ДАРГА, ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, АРХИВ, АЛБАН
ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН
АХЛАХ БАЙЦААГЧ Г.БИЛГҮҮН

2016 оны 11 дүгээр сарын 29 өдөр

**АЕГ-ЫН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
ХЭЛТСИЙН 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хяналт шалгалт хийх хугацаа:

Архивын ерөнхий газар /цаашид "АЕГ"/-ын Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн 2016 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө, Архивын ерөнхий газрын дэд дарга, даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын хяналтын Ахлах байцаагчийн баталсан энэхүү удирдамж, хуваарийн дагуу улсын байцаагч нар 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс 12 дугаар сарын 27-ны өдрүүдэд хяналт шалгалтыг явуулна.

1.2. Хяналт шалгалтын зорилго нь:

2015 оны Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг, 2016 оны Төрийн архивын улсын үзлэгийн дүнг үндэслэн илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, үзлэгийн мөрөөр хийж, хэрэгжүүлсэн ажлын биелэлтэд үр дүнгийн буюу давтан үзлэг хяналт шалгалт явуулж, цаашид авах арга хэмжээг тодорхойлох, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангахад оршино.

1.3. Үндэслэл болгох хууль тогтоомж:

Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Архивын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 164 дүгээр тогтоолоор батлагдсан "Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын хяналтын дүрэм", Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн MNS 5140-2011 стандарт, Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, Байгууллагын архивын ажлын үндсэн заавар, АЕГ-ын даргын 2009 оны 69 дүгээр тушаалаар батлагдсан "Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналт шалгалтын заавар"-ыг тус тус баримтална.

1.4. Үзлэгийн хамрах хүрээ нь 2016 оны Төрийн архивын улсын үзлэгт тодорхой шалтгааны улмаас хамрагдаагүй болон 2015 оны "Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг"-ээр доогуур үзүүлэлттэй байгууллагууд нь гүйцэтгэлийн буюу үр дүнгийн давтан хяналт шалгалтад хамрагдана. Үүнд:

1.4.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын төв архив

1.4.2 Хан Хэнтийн Улсын тусгай хамгаалалтын газрын хамгаалалтын захиргаа

- 1.4.3 Ойн судалгаа хөгжлийн төв
- 1.4.4 Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба
- 1.4.5 Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа

Хоёр. Хяналт шалгалтын чиглэл, үзүүлэлт

2.1. Хяналт шалгалтыг Төрийн архивын ажил, төрийн байгууллагын ажлын албан хэрэг хөтлөлт, байгууллагын архивын ажил гэсэн гурван үндсэн чиглэлээр дараах үндсэн үзүүлэлтээр шалгаж дүгнэнэ.

- 2.2 Төрийн архивын ажлын үндсэн чиглэл;
 - 2.2.1 Төрийн архивын үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт
 - 2.2.2 Төрийн архивын баримтын хадгалалт, хамгаалалт
 - 2.2.3 Төрийн архивын тоо, бүртгэл
 - 2.2.4 Төрийн архивын нөхөн бүрдүүлэлт
 - 2.2.5 Архивын баримтыг нягтлан шалгах ажлын арга зүй, зохион байгуулалт
 - 2.2.6 Төрийн архивын баримтын ашиглалт, үйлчилгээ
 - 2.2.7 Төрийн архивын цахим сан бүрдүүлэлт
 - 2.2.8 Төрийн архивын эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны сан
 - 2.2.9 Төрийн архивын мэргэжил, арга зүйн үйл ажиллагаа
 - 2.2.10 Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх мэргэжлийн хяналт

- 2.3. Төрийн байгууллагын ажлын албан хэрэг хөтлөлтийн чиглэлийн үндсэн үзүүлэлт;
 - 2.3.1 Албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалт
 - 2.3.2 Удирдлагын үйл ажиллагааны баримтжуулалт
 - 2.3.3 Баримт бичиг зохион бүрдүүлэлт
 - 2.3.4 Баримт бичигтэй ажиллах ажлын зохион байгуулалт
 - 2.3.5 Баримт бичгийн шийдвэрлэлтэнд хяналт тавих
 - 2.3.6 Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудасны хадгалалт, хамгаалалт, ашиглалт
 - 2.3.7 Албан хэрэг бүрдүүлэлт
 - 2.3.8 Төрийн албан ёсны хэлний тухай хууль болон нууцын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт

- 2.4 Байгууллагын архивын ажлын чиглэлийн үндсэн үзүүлэлт;
 - 2.4.1 Байгууллагын удирдлагаас архивын талаар авсан удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээ, үр дүн
 - 2.4.2 Байгууллагын архивын ажлын зохион байгуулалт
 - 2.4.3 Байгууллагын архивын нөхөн бүрдүүлэлт, архивт баримт хүлээн авах журам, түүний хэрэгжилт
 - 2.4.4 Баримт бичиг нягтлан шалгах комиссын үйл ажиллагаа, үр дүн
 - 2.4.5 Архивын баримтын тоо бүртгэл
 - 2.4.6 Архивын баримтын хадгалалт, хамгаалалт
 - 2.4.7 Архивын баримтын ашиглалт, архивын үйлчилгээ
 - 2.4.8 Архивын эрдэм шинжилгээний лавлах зохиож, хөтөлсөн байдал
 - 2.4.9 Төрийн архивт баримт шилжүүлэх журам, түүний хэрэгжилт

Гурав. Хяналт шалгалтын үр дүн, цаашид авах арга хэмжээг тодорхойлох

3.1. Хяналт шалгалтын ажлын дүнг улсын байцаагчийн дүгнэлт, илтгэх хуудас бичиж байгууллагын удирдлагад албан ёсоор танилцуулж, цаашид авах арга хэмжээний чиглэл өгнө.

3.2. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг газар дээр нь арилгуулах, хугацаатай үүрэг даалгавар өгөх, холбогдох мэргэжил арга зүйгээр хангана.

3.3. Хяналт шалгалтын талаарх мэдээллийг АЕГ-ын цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ.

3.4. Шаардлагатай тохиолдолд улсын байцаагчийн албан шаардлага, акт болон торгууль, шийтгэврийн хуудас оноож холбогдох арга хэмжээг авна.

3.5. Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагууд хяналт шалгалтын мөрөөр тодорхой ажил зохион байгуулж, хийсэн ажлын тайлан мэдээг улсын байцаагчийн заасан хугацаанд АЕГ-т ирүүлэх үүрэг хүлээнэ.

Дөрөв. Бусад зүйл

4.1 Хяналт шалгалтад хамрагдаж байгаа байгууллагууд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13.2 дах заалтыг үндэслэл болгон холбогдох баримт, мэдээллийг шуурхай гаргах, хяналт шалгалтын ажилд дэмжлэг тусалцаа үзүүлэх үүрэг хүлээнэ.

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

БАТЛАВ
 АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН
 ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ
 Г.БИЛГҮҮН

2016 оны 11 сарын 29

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСЭЭС
 2016 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРАЛД ЯВАГДАХ ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ
 ШАЛГАЛТЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2016.11.29

Д/д	Хяналт шалгалтад хамрагдах байгууллагын нэр	Хугацаа	Хяналт шалгалт хийх улсын байцаагчийн нэр	Хяналт шалгалтын төрөл					
				Төрийн архивын ажил		Албан хэрэг хөтлөлт		Архив	
				Иж бүрэн	Иж бүрэн	Сэдэвчилсэн	Иж бүрэн	Сэдэвчилсэн	
1	2	3	4	5	6	7	8	9	
Нэг. Төрийн архив									
1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын төв архив	12.07-12.13	Ч. Оюунчимэг Ө.Батсүрэн Т.Сайнжаргал	√					
Хоёр. Байгууллагын архив									
1	Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа	12.14-12.20	Ч. Оюунчимэг		√		√		
2	Ойн судалгаа хөгжлийн төв	12.14-12.20	Ө.Батсүрэн		√		√		
3	Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба	12.14-12.20	Т.Сайнжаргал		√		√		
4	Хан Хэнтийн Улсын тусгай хамгаалалтын газрын хамгаалалтын захиргаа	12.21-12.27	Ө.Батсүрэн		√		√		

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС